Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

АРВАЙХЭЭР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЦЭВЭЛСОДНОМЫН НАРАНБАДАМ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дуусгасан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗОРИЛТЫГ ХОТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, БУСАД ЭРХЗҮЙН АКТ БАРИМТУУДТАЙ УЯЛДУУЛАН ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ | | | | | | |
| 1.1 Тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөг аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлого, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн баримт бичиг төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг тооцох. | ЗДТГазарт саналаа хүргүүлж төлөвлөгөө боловсруулахад хамтран ажилласан байна. хэрэгжилт хувь | - 89 | 92.5 Хэрэгжилтийг тайлагнан ажилласан байна. | Жилийн хөгжлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичиг аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүдтэй уялдуулан ЗДТГазар, холбогдох албаны мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн сумын ИТХурлын 19 дүгээр хуралдаанаар 4 бүлэг 14 зорилт 24 арга хэмжээ хийгдэхээр хурлаар хэлэлцэн батлуулж биелэлтийг ханган ажиллаа. Нэг. Хүний хөгжил бүлгийн хэрэгжилт 94.8 хувь, Хоёр. Эдийн засаг бүлгийн хэрэгжилт 88 хувь, Гурав. Засаглалын бодлого бүлгийн хэрэгжилт 94 хувь, Дөрөв. Ногоон хөгжил аялал жуулчлал бүлгийн хэрэгжилт 92.5 хувьтай хэрэгжиж сумын үндсэн чиглэлийн хэрэгжилт 92.5 хувьтай биелэлттэй хэрэгжлээ. | 2024.01.02 2024.12.31 | 100 хувь |
| 1.2 Жил бүрийн хөгжлийн индексийг тооцож, | Байгууллага, аж нэгж | | Холбогдох байгууллагаас | Аймгийн ЗДТГазар, сумын ЗДТГазар, ЕБоловсролын 6 сургууль, | | |

80

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| баталгаажуулах. | бүрээр | | тоон мэдээллийг цуглуулж программд шивэлт хийсэн байна. | СӨБоловсролын 14 цэцэрлэг, БОЭТөв, 3 ӨЭМэндийн 3 төв, Манба дацан, Хөх манал уламжлалт эмнэлэг, Ариун санаа, Чин мэнд, Сидармед, Ачтан ирээдүй дотор хүүхдийн эмнэлэг, Монгол банкны салбар, Онги-Ус суваг ОНӨААТҮГазар, Өвөрхангай аймаг дахь ЭБЦТС ТӨХК, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Цагдаагийн газар, 8 зочид буудал, Хүүхдийн ордон, спортын ордон, усан бассейн, ХДТеатр зэрэг байгууллагуудын боловсрол, эрүүл мэнд, эдийн засаг, дэд бүтэц, байгаль орчин, бусад гэсэн өгөгдлүүдээр холбогдох байгууллагуудын тухайн ажлыг хариуцсан ажилтнаар дамжуулан мэдээллийг цуглуулж ирүүлсэн мэдээг (ldi.nda.gov.mn) орон нутгийн хөгжлийн индексийн программд шивэлт хийн цаг хугацаанд нь тайлагнан ажиллалаа. | 2024.10.05 | 100 хувь |
| ХОЁР. УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХИЙГДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТОДОРХОЙЛОХ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ , ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ; | | | | | | |
| 2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн санал авах, эрэмбэлэх, | Журмын дагуу | 2024 | Иргэдээс цахимаар болон цаасан хэлбэрээр санал авах ажлыг төлөвлөх, зохион байгуулах Саналыг нэгтгүүлэн БИНХурлаар эрэмблүүлсэн байна. | 1. Орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу иргэдээс цаасан болон цахим хэлбэрээр санал авсан. Санал авах ажлыг зохион байгуулахдаа дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ. Үүнд: Сумын ИТХурлын ажлын албатай хамтран 13 багийн ажлын албанд арга зүйн зөвлөмж, мэдээллийг танхимаар өгөн ажилласан. ОНХС гар утасны апплейкшнийг 63 аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, удирдлагын багуудад мөн БИНХурал, 1 дүгээр ээлжийн цэрэг татлага, иргэд олноор цуглардаг төв бараан зах, БОЭТөв, Авто тээврийн газуудаар сурталчлан таниулж санал аван ажиллаа. Санал | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэгтгэх өдрийн байдлаар авч үзэхэд: Цахим систем, ОНХС гар утасны апплейкнээр хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулсан 11 төсөл арга хэмжээний саналд дэмжсэн 2242, дэмжээгүй 159, нэмэлтээр 54 нийт 2401 саналыг ирүүлсэн байна.<br>2. БИНХурлаар эрэмблээд ирүүлсэн саналыг ажлын хэсэг зохих журмын дагуу эрэмбэлж сумын ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 6 төсөл арга хэмжээ, малын тоо толгойн албан татварын орлогоор 5 төсөл арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр саналыг сумын Засаг даргад хүргүүлсэн. Төсөвт өртөг өндөр сумын төсөв, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийгдэх боломжгүй 15 төсөл арга хэмжээний саналыг аймгийн ЗДТГазрын ХБТХОХэлтэст хүргүүлэн ажиллаа. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 хувь |
| 2.2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих. | ХҮА<br>Цахим системээр<br>тендерийн тоогоор | - | Худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр зохион байгуулж тухай бүрт урилга, үр дүн, гэрээг нийтэлсэн байна. Тухай бүрт тендерийн шалгаруулалтын баримт бичгийн бүрдүүлэлтийг хийсэн байна. | 1. Худалдан авах төлөвлөгөөний дагуу tender.gov.mn цахим системээр 16 тендерийг зохион байгуулснаас 15 тендер үр дүн гарч 1 тендер нээгдэх хугацаа болоогүй хүлээн авах шатандаа явагдаж байна. Ажлын гүйцэтгэлээр авч үзвэл: 11 ажил 100 хувь, 1 ажил 70 хувь, 3 ажил 30 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн байна.<br>2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийн бүрдлийг тухай бүрт нь хийн ажиллаж байна. | 2024.01.15<br>2024.12.31 | 100 хувь |
| 2.3 Тухайн жилд шинээр хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын талаар мэдээллийн сан бүрдүүлж хөрөнгө | Бүтээн байгуулалтын ажлын тоогоор, төсөвт өртөг | 22 | Бодит мэдээлэл дээр тулгуурласан байх | Улсын болон аймаг сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын талаар мэдээллийг нэгтгэн судалгааг гарган | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| оруулалтын жагсаалтыг жил бүр шинэчлэн гаргах | | | | ажиллаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: БШУЯамны багцаас 11,8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2 ажил БОАЖЯамны багцаас 2,5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1 ажил ХНХЯамны багцаас 4,2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1 ажил БХБЯамны багцаас 3,9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1 ажил СОЯамны багцаас 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2 ажил ЗГХЭГазрын 1,2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1 ажил, аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 20 ажлыг 1,8 тэрбум төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 13 ажлыг 3,4 тэрбум төгрөгөөр , аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 4 ажлыг 900 сая төгрөг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 23 ажлыг 1,6 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 12 ажлыг 1,1 тэрбум төгрөгөөр хийж хэрэгжүүлэхээр төсөвлөгдсөн мэдээ судалгаатай байна. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 хувь |
| ГУРАВ: ТОХИЖИЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖЛЫГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧИЛЖ, ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ; | | | | | | |
| 3.1 Орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд бодлого хөтөлбөр, төсөл төлөвлөгөөний хувилбар боловсруулж, дэмжлэг үзүүлэх. | Төсөл хөтөлбөрийн тоогоор | - | Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох | Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 12 төсөл арга хэмжээ хийж хэрэгжүүлэхээр төсөвлөгдсөнөөс 8 ажил тендер зарлагдаж, 4 ажил шууд худалдан авалт хийгдэж 9 ажил 100 хувь, 3 ажил 30 хувийн гүйцэтгэлтэй хийгдээд байна. Ажлын явцад сумын ИТХурлаас 2 удаа, ХЗАлбанаас явцын хяналтуудыг хийж заавар зөвлөмж өгөн ажиллаж байна. Төслийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд санхүүгийн хяналт, дотоод аудит, төрийн аудитаас хийгдсэн хяналт | 2024.01.15<br>2024.12.31 | 70 хувь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | шалгалт, нийцлийн аудитын дүгнэлт зөвлөмж нь цаашид төслийн үр дүнд эерэгээр нөлөөлж байна. | | |
| 3.2 Хариуцсан ажлын чиглэлээр үнэн зөв бодит мэдээллийг олон талт хэвлэлээр сурталчлах. ОНХ – | 13 Мэдээлэл хүргэх сувгийн тоогоор | 15 - | 13 Ажил үйлчилгээг иргэд олон нийтэд сурталчлан таниулах | Иргэдийг мэдээллээр хангах зорилгоор ОНХСангийн хөрөнгөөр 2023 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан гүйцэтгэл, 2024 онд ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалт, 2025 онд хийж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналын авах тухай постер, танилцуулга бэлтгэн ЗДТГазрын ХЗАлбаны мэдээллийн самбар, Арвайхээр сумын ЗДТГазар, Орон нутгийн хөгжлийн сангийн ажилтнууд, Орон нутгийн хөгжлийн мэдээллийн ажилтнууд, 13 багийн facefook групп, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бүлгэм, arvaikheer.uv.gov.mn зэрэг сайтуудад байршуулан сурталчлан таниулж 13 багийн ИНХурлаар давхардсан тоогоор 2000 гаруй иргэнд, 63 аж ахуйн нэгж байгуулагын удирдлага, удирдлагын багууд болон хүн ихээр төвлөрсөн төв бараан зах, төв талбай, БОЭТөв, авто тээвэр зэрэг газруудаар нийт давхардсан тоогоор 2600 гаруй иргэн мэдээлэл хүргэн ажиллаа. Худалдан авах ажиллагааны тайлан, ажлын явцын талаар хагас бүтэн жилээр гарган https://arvaikheer.uv.gov.mn/ сайтад байршуулан ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 хувь |
| ДӨРӨВ. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БУСАД ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ; | | | | | | |
| 4.1 Төрийн албаны тухай хууль, ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллах. | Хууль, тогтоомж, дүрэм журмыг хүрээнд | - | Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж төрийн албан хаагчийн | Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын ёсзүйн дүрэм, бусад хууль тогтоомж дүрэм, журмыг даган мөрдөж мөрдлөг болгон ажиллаа. Ямар нэгэн ёсзүйн зөрчил дутагдалгүй, сахилга батыг чанд | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ёсзүйн хэм хэмжээ, төрийн албаны нэр хүндийг дээдлэх | баримтлан ажиллаа.<br>Төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүртээмжтэй, ил тод, ялгаваргүй хүргэн ажилласан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 хувь |
| 4.2 Албан тушаалын чиг үүргийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд чиглэсэн сургалт хийх, үйл ажиллагаагаа ил тод нээлттэй тайлагнах, мэдээлэх. | Арга хэмжээний тоогоор | - | Иргэдэд мэдээлэл хүргэн сурталчлан таниулах | Хариуцсан ажлын чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалт цахим удирдлагын систем (апплейкшн)-ийг олон нийтэд сурталчлан таниулах утсанд нь суулгаж тухайн орон нутагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг өгөх талаар цахим апплейкшнийг сурталчлан ажилласан. Мөн “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн хүрээнд 13 багийн ажлын алба, ЗДТГазрын мэргэжилтнүүдтэй хамтран явуулын цахим үйлчилгээг давхардсан тоогоор 600 гаруй иргэнд сурталчлан таниулан ажилласан. 5 дугаар багийн ажлын албатай хамтран 2 дугаар сургуулийн 12 дугаар ангийн сурагчдад сумын ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний саналыг цаасан болон цахим хэлбэрээр хэрхэн өгөх талаар мэдээлэл хүргэн ОНХС апплейкшныг сурталчлан таниулж гар утсанд суулган санал аван ажиллаа. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 хувь |
| 4.3 Албан бичиг болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | Өргөдөл гомдлын тоогоор | - | Тухай бүрт нь шийвдэрлэн ажилласан байна. | Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар 1 удаа гомдол ирснийг цаг хугацаанд нь холбогдох байгууллага албан тушаалтанд хариу мэдэгдэж хамтран ажилласны үндсэн дээр үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй болох талаар шийдвэр гарч маргаан шийдвэрлэгдсэн. Хариуцсан ажлын чиглэлээр иргэнээс ямар нэгэн өргөдөл, гомдол ирүүлээгүй. Бусад асуудлаар: 1 гомдол, 2 хүсэлт ирснийг албаны ерөнхий | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | менежерт танилцуулж холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлан хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэн иргэнд хариуг мэдээлэн ажиллаа. | 2024.01.02 2024.12.31 | 100 хувь |
| 4.4 Файлын эмх цэгцийг сайжруулах, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтыг эмхлэн цэгцэлж, бүрэн бүрдэлтэй нь байгууллагын архивт хүлээлгэн өгөх. | Стандартын дагуу | - | Цахим архивын нэгж үүсгэн нэр өгч folder болгон хадгалсан байна | Компьютер дахь цахим мэдээллээ folder үүсгэн нэр өгч мэдээллийн чиглэлээр нь багцлан хадгалсан. 13 багийн 2023, 2024 оны ОНХСангийн саналын хуудас бусад холбогдох бичиг баримтыг цэгцлэн баг багаар нь нэгж үүсгэн хавтаслан үдэж бэлтгэсэн. Мөн худалдан авах ажиллагааны материалыг бараа, ажил үйлчилгээ тус бүрээр нь хавтаслан бэлтгэсэн. Тухайн оны архивын материал хүлээн авах хуваарийн дагуу хүлээлгэн өгөхөд бэлэн болсон. ОНХСангийн 2020, 2021, 2022 оны материалаа стандартын дагуу үдэж бэлтгээд архив бичиг хэрэг хариуцсан ажилтанд хүлээлгэн өгсөн. Ирсэн, явсан албан бичиг бусад бичиг баримтыг тус албаны орчны эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч бүртгэлжүүлэн хариу арга хэмжээг заасан хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. | 2024.01.02 2024.12.31 | 100 хувь |
| 4.5 Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцан ажиллах. | Чиг үүргийн дагуу | - | Ажлын явц үр дүнг тухай бүрт танилцуулан үүрэг чиглэл авсан байна. | 1. Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу tender gov.mn, тендерийг байршуулан зохих хууль тогтоомжийн дагуу шалгаруулалтыг явуулж нягтлан бодогчийн гүйцэтгэл, хэрэгжилтийн тайлан мэдээтэй нийлж үр дүнг тооцон Удирдлага мэдээллийн системд мэдээллийг оруулж ЗДТГазар, санхүүгийн албанд мэдээ тайланг тайлагнан ажиллаж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг зохих журмын дагуу Удирдлага мэдээллийн | 2024.01.02 2024.12.31 | 100 хувь |

86

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | системд цаг хугацаанд нь тайлагнан ажиллаж байна.<br>2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас бүтэн жилээр тайлагнан ажиллаж байна. | | |
| 5. МЭДЛЭГ УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ТУСГАЙ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ | | | | | | |
| Боловсрол, мэргэжил, мэргэшил ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | - | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 5.1 Canva программ | Мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна. | - | Албан хэрэгцээнд ашиглаж сурсан байна | Бие даан суралцаж албан хэрэгцээнд хэрэглэж байна. | 2023.01.02<br>2023.12.31 | 70 хувь |
| 5.2 Prezi программ | Мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна. | - | Албан хэрэгцээнд ашиглаж сурсан байна | Бие даан суралцаж албан хэрэгцээнд хэрэглэж байна. | 2023.01.02<br>2023.12.31 | 70 хувь |

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

(Ц.НАРАНБАДАМ) ....................
(Нэр, гарын үсэг)

2024.11.20
(Огноо)

87